



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/124

Чойр

Нэгдсэн эргүүл шалгалт, сурталчилгааны ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Онцгой байдлын ерөнхий газрын 2023 оны “ой хээрийн түймрээс 01 дүгээр албан даалгавар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аймгийн 2023 оны төсвийг батлах тухай” 05 дугаар тогтоолын 05 дугаар хавсралтаар батлагдсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний жагсаалт”-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчил, шар усны үер, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хүрээнд иргэдийг болзошгүй эрсдэлээс сэргийлэх мэдлэг мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх, мал амьтны сэг зэм устгалын ажилд хяналт тавих зорилгоор нэгдсэн эргүүл, хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлыг хаврын улиралд 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01, намрын улиралд 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Нэгдсэн эргүүл, хяналт шалгалт, сургалт сурталчилгааны ажлын удирдамжийг 1 дүгээр, төсвийн задаргааг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Нэгдсэн эргүүл, хяналт шалгалтын ажилд шаардагдах 3,425,200 (гурван сая дөрвөн зуун хорин таван мянга хоёр зуу) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Д.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Эргүүл, хяналт шалгалт, шар усны үер, мал амьтны сэг зэм устгалын хяналт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг хуваарийн дагуу нэгдсэн удирдамжаар хангаж, зохион байгуулж, тайлагнахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Д.Мөнх-Эрдэнэ), Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Х.Сүхбаатар) нарт, малчид иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлж, сумдын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулан ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400296

Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 29-ны өдрийн
дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт

НЭГДСЭН ЭРГҮҮЛ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ, СУРГАЛТ
СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Байгаль орчныг хамгаалах, Гамшгаас хамгаалах, Ойн тухай хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх болон хаврын хуурайшилтын үе эхэлж байгаатай холбогдуулан тус аймгийн хэмжээнд болзошгүй хээрийн түймэр, шар усны үер, байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мал амьтны сэг зэм устгалын ажилд хяналт тавих зорилгоор эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулж ард иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, анхааруулга сэрэмжлүүлэг өгч иргэдийн бүлэг нөхөрлөлүүдийг чадавхжуулан ажиллахад оршино.

Хоёр. Хугацаа

Эргүүл хяналт шалгалтын ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 01, намрын улиралд 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэх ба цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч уг хугацааг өөрчилж болно.

Гурав. Үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулж, хэрэгжүүлэх

Д/Д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага
Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд		
	Хээрийн түймэр гарах эрсдэлтэй Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын хөдөөгийн багт байгуулсан бүлэг, нөхөрлөлийн урьдчилан сэргийлэх талаар уулзалт ярилцлага хийх, гарын авлага материал тараах	ОБГ, БОАЖГ, ЦХ, СУМДЫН ЗДарга нарт
	Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.30-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн аюултай үед албан хаагчид, олон нийтийг татан оролцуулах	
	Хээрийн түймэр, байгаль орчны гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын талаар мэдээ мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	
1. Онцгой байдлын газрын дарга, хурандаа Х.Сүхбаатарт		
1.1	Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1., 17.1.2, 17.1.5, 17.2.2, 17.2.7, 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.8, 18.2.10, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.4, 1.7-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө, төсвийг бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг тайлагнах	
1.2	Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн дугаар 68 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар "хээрийн гал түймрийн эрсдэлийн тойм судалгаа (ерөнхий үнэлгээ)-г хийх аргачлалын дагуу орон нутгийн ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг нутгийн захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн оролцоотой хийлгэх	
1.3	Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.14, 17.2.15, 17.2.20, 18 дугаар зүйлийн 18.2.4, 18.2.5, 18.2.11, 18.2.17, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасны дагуу болон эрсдэлийн үнэлгээтэй уялдуулан аймаг сумын хэмжээнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт, дадлага зохион байгуулах төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангуулах	
1.4	Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан "Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам", "Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах	

	журам"-д заасны дагуу сайн дурын хэсгийн дарга, жолооч, гал сөнөөгчийн мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан сургалт зохион байгуулах
1.5	Төв, орон нутгийн телевиз, радио, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчныг ашиглан хавар, намрын хуурайшилтын болон зуны хэт халалтын үед иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах чиглэлээр сэрэмжлүүлэг, мэдээ мэдээлэл түгээх
1.6	Онцгой байдлын ерөнхий газраас 2024 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэн, ой, хээрийн гал түймрээс хамгаалах ажиллагаанд оролцогч талуудтай харилцан ажиллагааны санамж бичиг, төлөвлөгөө байгуулж хамтарсан дадлага сургалтыг зохион байгуулах
1.7	Ой, хээрийн гал түймрийн эрсдэл бүхий бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа айл өрх, амралтын газар, аялал жуулчлалын бааз зэрэг аж ахуй нэгж, байгууллагуудад Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, ой, хээрийн гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангуулах
1.8	Ой, хээрийн гал түймрийн аюултай үе буюу жил бүрийн 3 дугаар сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд болон зуны хэт халалтын үед Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.8, 18 дугаар зүйлийн 18.2.12, 18.2.14-д заасныг хэрэгжүүлэн орон нутгийн төрийн захиргааны байгууллагатай хамтран байнгын хяналт, шалгалтын цэг, хөдөлгөөнт эргүүл томилон ажиллуулах
1.9	Ой, хээрийн гал түймэр унтраах томилгоот бүрэлдэхүүн, түймэр унтраах ажиллагаанд дайчлагдан ажиллах мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг, иргэдийн хувийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, автомашин техник, тоног төхөөрөмж, бүх төрлийн багаж хэрэгслийн засвар үйлчилгээг хийж, аюулгүй найдвартай ажиллагааг хангах, шаардлагатай сэлбэг, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх
1.10	Байнгын болон ой, хээрийн гал түймрийн үед ашиглах холбоо, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн ажиллагаа, холбооны чанар байдлыг шалгаж, бэлтгэл бэлэн байдлыг хангах
1.11	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны А/346 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам"-ын 10.2 дахь заалтыг хэрэгжүүлэн орон нутагт байгуулагдсан Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн гал унтраах зориулалтын автомашин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, гал түймрийн дуудлага хүлээн авах зориулалт бүхий суурийн болон хөдөлгөөнт холбооны хэрэгслийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх талаар анхаарч, нутгийн захиргааны байгууллагатай хамтарч ажиллах
1.12	Бие бүрэлдэхүүнийг ой, хээрийн гал түймрийн дуудлагаар гарч ажиллах, буцах, түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх үед Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гал түймэр унтраах дүрэм", Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/338 дугаар тушаалаар батлагдсан "Онцгой байдлын ерөнхий газрын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм" болон Засгийн газрын 2018 оны 239 дугаар тогтоолоор батлагдсан "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм"-ээр сургалт зохион байгуулж, холбогдох заалтуудыг чанд сахин мөрдөж, хэвшүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих
1.13	Ой, хээрийн гал түймрийн дуудлага ирсэн даруйд Онцгой байдлын газрын Эрэн хайх аврах бүлгийн томилгоот ээлжийн бүрэлдэхүүнийг эхний дуудлагаар шуурхай гаргах, Эрэн хайх, аврах нэгжгүй орон нутагт Гал түймэр унтраах аврах анги, орон нутгийн мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнийг гаргах, нэмэлтээр гарах бүлгийг богино хугацаанд бэлэн байдлыг хангуулах
1.15	Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар ажиллах бүрэлдэхүүнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн зааварчлаг өгч баталгаажуулан, байршил тодорхойлогч /GPS/, салхины чиг, хурд хэмжигч, сансрын холбооны утас /IRIDIUM/, богино болон хэт богино долгионы гар, суурийн холбооны хэрэгсэл, байр зүйн зургаар хангаж шуурхай дуудлагаар ажиллах

1.16	Ой, хээрийн гал түймрийн мэдээ, мэдээллийг хүлээн авсан албан тушаалтан, бүсийн төвийн зохицуулагч нар цаг агаарын болон ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын ой, хээрийн гал түймрийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт цаг алдалгүй шуурхай мэдээлэх
1.17	Ойн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-д заасныг хэрэгжүүлэн Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам"-ын дагуу экологийн болон эд хөрөнгөд учирсан хохирол, түймрийг унтраахад гарсан зардлыг хуулийн хугацаанд үнэн зөв тооцох хяналт тавихад орон нутгийн Байгаль орчны газартай хамтран ажиллах
2. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Д.Мөнх-Эрдэнэ	
2.1	Ой, хээрийн түймэр гарах эрсдэл өндөртэй аймаг, сумдад Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд, Засгийн газрын 213 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулан техник багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэн ажиллах
2.2	Ус Цаг Уур, Орчны судалгаа, Мэдээллийн Хүрээлэнгийн сансрын хиймэл дагуулын мэдээллээр авсан цаг агаарын болон ой, хээрийн гал түймрийн голомт, тархалтын зураг, хуурайшилтын мэдээг тухай бүр /баяр амралтын өдрүүдэд/ шуурхай боловсруулж, Онцгой байдлын газарт хүргүүлэх
2.3	Ойн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.13-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс сэрэмжлүүлэг, орон нутагт эргүүл, харуул ажиллуулах болон энэ ажилд бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах
2.4	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 153 дугаар зарлигийн хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.4-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй бүс нутагт гал түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын нислэг үйлдэх зардлыг төсөвт тусгаж, Зэвсэгт хүчний байгууллагатай хамтран нислэг үйлдэх
2.5	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 153 дугаар зарлигийн хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2.15-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, аюул тулгарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зохион байгуулалтын талаар олон нийтийг мэдээлэл, заавар, зөвлөмжөөр хангах, нэвтрүүлэг бэлтгэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах
2.6	Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, сумны нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, шаардлагатай үед ашиглах
2.7	Ойн тухай хуулийн дагуу хавар, намрын хуурайшилтын улиралд ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглах, аялал зугаалгаар явах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах, холбогдох хууль хяналтын байгууллагуудтай хамтран хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, хууль дүрэм, журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэх
2.8	Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх, усан сан, цөөрөм байгуулах ажлыг зохион байгуулах
2.9	Ой сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийг Зөрчлийн тухай хуульд зааснаар арга хэмжээ авч, улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч нарын ажлыг эрчимжүүлж ажиллах
2.10	Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэх
2.11	Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасныг зөрчиж ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцох
2.12	Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт заасныг зөрчиж ойн тухай хуулиар тогтоогдсон шаардлагыг биелүүлээгүй хүн хуулийн этгээдэд хариуцлага тооцох

2.13	Өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотой үхсэн сумдын мал амьтны сэг зэм устгалын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, устгалын талбайн аюулгүй байдлыг хангуулах
2.14	Байгалийн гамшигт өртсөн зэрлэг амьтадын сэг зэм устгалын ажил зохион байгуулах
3. Цагдаагийн хэлтсийн дарга, Ц.Баярхүүд	
3.1	Ойн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д заасныг хэрэгжүүлэн ой хээрийн гал түймрийн шалтгаан, эзэн холбогдогчийг тогтоох, энэ тухай холбогдох мэдээллийг улирал бүр Онцгой байдлын ерөнхий газар болон Улсын Онцгой комисст ирүүлэх
3.2	Ойн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасныг хэрэгжүүлэн ой хээрийн гал түймрийн аюултай үед ойд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглох, орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран байнгын болон хөдөлгөөнт хяналт, шалгалтын цэг ажиллуулах
3.3	Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/16, А/10 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан объектын болон ой, хээрийн гал түймрийн үед хамтран ажиллах журмыг хэрэгжүүлэх
3.4	Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд бөгөөд штабын дарга, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн Цагдаагийн албаны дарга нарын 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдөр баталсан ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
3.5	Ой, хээрийн гал түймрийн талаарх мэдээ, мэдээллийг хүлээн авсан тухай бүр төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад мэдэгдэх, харилцан шуурхай мэдээ, мэдээлэл солилцох
4. Сумын Засаг дарга нарт	
4.1	Ойн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн цагийн байдлын тухай мэдээг Онцгой байдлын байгууллагад тухай бүр болон хагас жилээр гаргаж өгөх
4.2	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэн нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн ой, хээрийн гал түймэр унтраахад дайчлах гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах тэдгээрийг ой хээрийн гал түймрийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадварыг дээшлүүлэх
4.3	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д заасныг хэрэгжүүлэн нутаг дэвсгэртээ гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгах
4.4	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй газарт түймэр тархахаас урьдчилан сэргийлэх зурвас шинээр байгуулах, зурвасыг сэргээх төсөв, төлөвлөөг аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, батлуулж, хэрэгжүүлэх
4.5	Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5-д заасныг хэрэгжүүлэн, гал түймэртэй тэмцэх, сайн дурын хэсгийн ажилтнуудад хууль, эрх зүйн болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан ой, хээрийн гал түймрийн шуурхай унтраах мэдлэг олгох, дадлагажуулах, ажилтнуудын бэлтгэл бэлэн байдлыг хангуулах сургалт дадлагыг аймгийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулж, шаардлагатай зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлүүлэх
4.6	Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.13-д заасныг хэрэгжүүлэн ой хээрийн гал түймэр гарсан үед бүрэн эрхийнхээ хүрээнд хүн хүч, техник хэрэгслийг дайчлан, гарсан гал түймрийг унтраах ажлыг шуурхай зохион байгуулах
4.7	Ойн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс учирсан хохирлыг хуулийн хугацаанд тогтоож, тайланд тусгах
4.8	Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 1.7.1-д заасныг хэрэгжүүлэн хавар, намрын хуурайшилтын улиралд Засаг даргын захирамжаар хуваарь гарган хөдөлгөөнт эргүүл, шалгалт хийх, шаардлагатай газар нутагт хяналтын цэг байгуулан ажиллуулах

4.9	Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасны дагуу сум, дүүргийн нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх тэмцэхэд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгслийг бэлтгэх, бэлэн байдлыг хангуулах
4.10	Ой хээрийн гал түймэр унтраахад дайчлах гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн ой, хээрийн гал түймэр унтраах сургалт, дадлагыг зохион байгуулах
4.11	Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний орон нутгийн хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг батлуулан хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих
4.12	Ой хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрч аймаг, нийслэлээс нэмэлт хүн хүч дайчлан ажиллах үед бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор харьяа эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагаас тусгай баг томилон ажиллуулах,
4.13	Бүх шатны засаг дарга нар 3 дугаар сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хуурайшилтын “аюултай”, “нэн аюултай” зэрэгт хүрсэн үед ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах нөөцийг ашиглах, аялал зугаалгаар явах болон бусад үйл ажиллагааг хязгаарлах захирамж гарган хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах
4.14	Өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой үхсэн мал амьтны сэг зэм устгалын ажлыг зохион байгуулан ажиллах.

Дөрөв. Илэрсэн зөрчлийг шийдвэрлэх

Эргүүл шалгалтаар илэрсэн хууль бус үйлдлийг таслан зогсоож холбогдох байгууллагад шилжүүлэн хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллана.

Тав. Үр дүнг тайлагнах

Холбогдох байгууллагууд өөрсдийн хуваарьт өдрөө эргүүл шалгалтын ажлыг ахлан зохион байгуулж албаны унаагаараа тухайн байгууллагын удирдлагаас батлагдсан чиглэлийн дагуу хуваарилсан шатахууны хязгаарт багтаан эргүүл хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэнэ. Эргүүл шалгалтын ажлыг гүйцэтгэхдээ бусад байгууллагуудын төлөөллийг оролцуулсан байна. Үүнд: Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цагдаагийн хэлтсийн төлөөллүүд зайлшгүй хамрагдсан байна.

Тухайн хяналт шалгалтыг ахлан хийсэн байгууллага /сумдын хувьд байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч/ ажилтан ажлын тайлангаа холбогдох баримт, фото зурган мэдээлэл, жолоочийн замын тооцооны хуудасны хамт баталгаажуулан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тухай бүрд ирүүлж тайлагнан шатахууны тооцоог дуусгана.

Захирамжийн биелэлт, тайлан мэдээг 2024 оны 6 дугаар сарын 10, 11 дүгээр сарын 01-ний дотор Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлж нэгтгүүлнэ.

Байгууллагуудаас ирсэн тайлан мэдээг Байгаль орчин, аялал жуулчлалын газар нэгтгэж 2024 оны 6 дугаар сарын 15, 11 сарын 10-ны өдрийн дотор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон АЗДТГ-ын Хяналт – шинжилгээ, үнэлгээний хэлтэст тус тус хүргүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2024 оны
03 сарын 29-ны өдрийн 4/м дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

ЭРГҮҮЛ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХУВААРЬ, СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДАЛ

/Шатахууны тооцоо/

№	Эргүүл, шалгалтаар явах газрын нэр	Эргүүл шалгалтаар явах хугацаа /сар, өдөр/		Эргүүл шалгалт хийхэд 1 удаа явах км	Нийт эргүүл шалгалтаар явах давтамжын тоо	Нэг удаад зарцуулагдах шатахуун /литр/	Нийт зарцуулагдах шатахуун /литр/	1 литр шатахууны үнэ /төг/	Нийт шаардагдах үнэ /төг/
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	IV /05 IV/26	09/25 10/15	400	4	40	160	2,480	396800
2	Онцгой байдлын газар	IV /11 V/03	10 /11 11/10	400	4	40	160	3,780	604,800
3	Сүмбэр сум	IV/18	11/10	400	2	40	80	2,480	198,400
4	Баянтал сум	IV/ 20 V/11	09/ 20 11/10	300	4	30	120	2,480	297,600
5	Шивээговь сум	IV/15 V/23	09/20 11/10	300	4	30	120	2,480	297,600
дүн				-	18	-	320	-	1,795,200
Үйл ажиллагаа		Үлээгч аппаратны шатахуун /литр/							
Нөхөрлөлийн ашиглах, үлээгч аппаратны шатахууны зардал		1 жилдээ			200			2,480	496,000
Зэрлэг амьтны сэг зэм устгалын ажлыг зохион байгуулах		1 жилдээ			300			3,780	1,134,000
Гэнтгийн ослын үед зарцуулах шатахууны зардал									
Нийт дүн					-			-	3,425,200